

Манмин Мэдээ

№ 31 2013 оны 2-р сарын 3



Хүн төрөлхтөн рүү хандсан Бурханы гашуудан буй хайрыг агуулсан 2013 оны Манмины дөрвөн залбирлын сэдэв, ба алсын хараа.

Хүн төрөлхтөн рүү хандсан Бурханы гашуудан буй хайрыг агуулсан 2013 оны Манмины дөрвөн залбирлын сэдэв, ба алсын хараа.

Эцэс төгсгөлийн энэ үед Бурханы агуу хайр, ба зорилго дотор байгуулагдсан манай Манмин төв сүм нь өнгөрсөн 30 жилийн турш зөвхөн итгэлээрээ дэлхийн хязгаар хүртэл сайн мэдээг тараан, Бурханыг алдаршуулсаар ирсэн билээ.

Дэлхийн өнцөг булан бүрт 10,000 гаруй салбар болон хамтарсан сүмүүдтэйгээ хамт бүх үндэстэнд авралын сайн мэдээг хүргэхийн төлөө тасралтгүй зүтгэсээр ирсэн ба ном, сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх дэлхийд Бүтээгч Бурхан ба Есүс Христ, Ариун сүнсний хүч нөлөөг тунхагласаар ирсэн билээ. Мөн асар хурдацтай Сүнсний урсгалын дунд олон хүмүүсийг авралд хүргэх төдийгүй, итгэлийн хадан суурийг өнгөрч, цаашлаад сүнслэг хүн болж, Төгс сүнсний хүн болох ерөөлийн цаг байлаа.

Ирж буй 2013 онд найдвар хүсэл дотор Доктор И Жей руг тэргүүн пастор 2013 оны сүмийн алсын харааг танилцуулсан бөгөөд Бурханы өгсөн уг болон, залбирлын сэдвүүдийг 2012 оны 12-р сарын 23ны ням гаригийн өглөөний Хүндэтгэлийн цуглаан, Баасан гаригийн оройн цуглаан, Шинэ он угтах цуглаанаар дамжуулан бүх итгэгч нартаа шинэ оны 4 залбирлын сэдэв, ба алсын харааг дамжуулсан билээ.

1. Эцсийн үеийн хүсэл зорилго (1Тимот 2:4)

Бүх хүмүүсийг авралд хүрэхийг үнэхээр хүсэж буй Бурханы хайрын сэтгэлийг илэрхийлж байна. Бурхан дэлхийн даяарх бүх хүмүүс, бүх үндэстнүүд энэ ариун сайн мэдээг сонсож, аврагдаасай хэмээн хүсч байна. Үүний тулд Бүтээгч Бурханы агуу хүч чадал төдийгүй үүнийг биелүүлэх сүнслэг дайчид зайлшгүй хэрэгтэй билээ. Эцсийн үеийн хүсэл зорилгийг төгс биелүүлэхийн тулд бид бүхэн бүр илүү хоньчинтойгоо нэгдэж, илүү ариун байдлыг олсон жил байх хэрэгтэй.

2. Төгс Сүнс (Еврей 10:22)

Энэ сүмийн нэр болон Бурханы эрх мэдэлт хүчийг бүх дэлхийн ард түмэнд төгс илчлэн харуулахын тулд Бурхан энэ шинэ онд олон хүмүүсийг сүнслэг болон Төгс сүнс рүү оруулахын тулд нөлөөлөх болно. Тиймээс, бид итгэлийн хадан суурь эсвэл сүнслэг байдлыг олсон ч тэр хэвээр байлгүй цаашлан төгс сүнсний зүрх сэтгэлийг хүсэн тэмүүлж, улам төгс итгэлийг олохын төлөө илүү хичээн зүтгэх зайлшгүй шаардлагатай болоод байна.

3. Бүх дэлхийд гэрэлтэх Өргөө сүм (Дуулал 37:6)

Бурханы шударга ёс энэ газрын харанхуй байдлыг гэрэлтүүлж үй олон хүмүүсийг цуглуулан, өөрчлөх жинхэнэ утгаар нь харуулж чадсан Өргөө сүмийг

хэлж байгаа юм. Гэхдээ сүмийн барилга л сүр жавхлан, үзэсгэлэнтэй байхаас илүү түүн дотор хуран чуулах итгэгч нар гэрэлтэж байж л ариухан сүм болохынхоо үүргийг биелүүлэх боломжтой. Бурхан ариун байдлыг олсон үр хүүхдүүдээр босгосон өргөө сүмээр дамжуулан бүх дэлхийд Бурханы алдрыг илэрхийлэхийн төлөө хоньчны эрх мэдэлт хүчийг улам их болгож итгэгчдийн итгэлийг өсгөсөөр ирсэн билээ. Манмины нэрээр баригдах үзэсгэлэнтэй, саруулхан өргөө сүмээр дамжуулан Бурханы алдар агуу ихээр илчлэгдэж, эцсийн үед үй олон хүмүүс аврал авах болно.

4. Эрх Мэдэлт Хүч Чадал (Иохан 11:41-44)

Иохан 11-р бүлэгт Есүс нас бараад дөрөв хоносон Лазарыг амилуулсан үйл явдал гардаг. Энэ мэт үхсэн нэгэнийг ч хүртэл амьдруулах эрх мэдэлт хүч чадал байдаг бол амьд нэгний чөлөөт сонголтыг ч өөрчлөх боломжтой тул олон хүмүүс авралд хүрэх боломжтой болох юм. Бурхан Есүст угийн дуу хоолойгоор дамжуулан үхсэн хүнийг амилуулсан шиг манай цуглаанд ч гэсэн хоньчноор дамжуулан угийн дуу хоолой гарах хүртэл удирдаж байгаа билээ. Шинэ онд хүссэнээрээ угийн дуу хоолой илчлэгдэж, дэлхийн үй олон хүмүүсийг авралын зам руу замчилж, илүү олон хүмүүсийг шинэ Иерусалимд оруулах юм.

Сүнслэг хайрын ач холбогдол

“Хэрэв би хүмүүсийн болон тэнгэр элч нарын хэлээр ярьсан ч надад хайр байхгүй бол нүргэлэх харанга, хангинах цан болох байсан. Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр байхгүй бол би юу ч биш. Хэрэв би өөрийн бүх л өмч хөрөнгөө тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч надад хайр байхгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм” (1Коринт 13:1-3).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

“Хайрын Бүлэг” гэж нэрлэдэг 1Коринт 13-р бүлгийг үзвэл сүнс зүгийн хайрын тухай тайлбарлахын өмнө хайрын ач холбогдолыг өгүүлсэн байдаг. Хэдийгээр бид дутагдах зүйлгүй хангалттай хоол хүнс, хувцас хунар, амьдрах орон байртай байсан ч бидэнд хайр байхгүй бол итгэл найдвар байхгүй, амьдрал ямар ч утга учиргүй, байх болно. Өөрөөр хэлбэл, хайр бол бидний амьдралын хамгийн чухал хүчин зүйл юм.

1Коринт 13:13-т “Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг боловч хамгийн агуу нь хайр мөн” гэсэн байдаг. Хэрэв бид тэнгэр элч шиг үзэсгэлэнтэй сайхан ярьдаг байсан ч, эш үзүүлэх билэг авьяастай байсан ч, уулыг хөдөлгөх агуу итгэлтэй байсан ч, бүх эд хөрөнгөө ядууст зориулсан ч, өөрсдийгөө шатаахаар тушаасан ч бидэнд сайн үйл хийхэд жинхэнэ үнэн хайр хэрэгтэй.

1. Хэрэв бид тэнгэр элч нарын болоод хүмүүсийн хэлээр ярьдаг байсан ч

Энд “Хүмүүсийн хэл” гэдэг нь Ариун Сүнснээс өгөгддөг бэлгүүдийн нэг болох харь хэлээр ярих чадвар биш харин дэлхий дээр хэрэглэгддэг Англи, Хятад, Орос гэх мэтийн хэлийг илэрхийлж байгаа юм. Бид хүн төрөлхтөний соёл иргэншил үр удам, хойч үеийхэнд нь хэлээр дамжин хэрхэн яаж хөгжин цэцэглэж байгааг мөн үгний хүч чадал ямар аймшигтай болохыг ч харж болно.

Үг хэлэнд хүний сэтгэлийг хөдөлгөх хүч байдаг ба олон зүйлийг биелүүлж чадах хүч бий. Ялангуяа бид тэнгэр элч шиг үзэсгэлэнтэй уянгалаг дуу хоолойгоор үргэлж гоё, дандаа л сайн сайхан зүйлийг ярьдаг байсан бол ямар сайхан байх бол!

Гэтэл хүмүүсийн чадварлаг яриа болон тэнгэр элч шиг үзэсгэлэнтэй хэлээр ярьдаг байсан ч сүнслэг хайр байхгүй

бол нүргэлэх харанга, хангинах цан мэт болох юм. Хангинах цан гэдэг нь хоосон хөндий эсвэл хөнгөмсөг гэдгийн баталгаа мөн. Яг үүнтэй адил хүн сүнслэг хайр байхгүй бол зүгээр л нэг хогын ургамал мэт байх болно. Бидний сэтгэл хайраар дүүрч, Бурханыг дуурайсан жинхэнэ үр хүүхэд, болох үед л хүн төрөлхтөнийг дасгалжуулж, боловсруулсан Бурханы өмнө үр тариа мэт үнэ цэнэтэй байж чадна. Бид ямар нэг зүйлийг хэлэхдээ сонсож байгаа хүндээ амь амьдрал өгч, “ямар үгээр би энэ хүнийг зоригжуулах вэ?”, “Би энэ хүнийг яаж үнэний зам руу ирэхэд нь туслах вэ?” гэж үргэлж бодох хэрэгтэй юм.

Иохан номын 8-р бүлэгт, Фарисайчууд болон хуулийн багш нарт завхайрч байгаад баригдсан нэгэн эмэгтэйд Есүсийн өмнө авчраад “Мосегийн хуульд ийм эмэгтэй рүү чулуу шидэгтүн гэж тушаасан. Харин Багш та юу гэж хэлэх вэ?” гэж асуудаг билээ. Хэрэв хуулийн дагуу “чулуу шид” гэж айлдвал тэд Есүсийг хайргүй гэж хэлэх байсан ба түүнийг уучил, өршөө гэж айлдвал тэд Түүнийг хуулийг үл тоосон гэж шүүмжлэх байсан нь мэдээжийн хэрэг байлаа. Энэ үед Есүс газарт тэдний гэм нүглийг нэг нэгээр нь бичиж эхэлсэн ба газарт бичигдсэн өөрсдийнхөө гэм нүглийн жагсаалтыг хараад тэд дотроо ичиж хэлэх үггүй болоод тэндээс явцгаажээ. Зөвхөн Есүс л нөгөө эмэгтэйд хамт тэнд үлдсэн байлаа. Есүс түүнд “Би ч гэсэн чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд” гэж айлдсан юм.

Энэ мэт сүнслэг хайр агуулсан үгэнд амь, амьдралыг дахин амилуулах гайхамшигтай хүч байдаг ч харьцаж буй хүнээ шууд ятган зааварчлах юм уу, зэмлэн буруушааж байсан ч тэр үг тань зуун хувь үнэн байсан ч хүнийг өөрчлөх, жинхэнэ амийг өгөх чадваргүй байдаг билээ. Тиймээс ямар нэг үг хэлэхдээ өөрийнхөө санаа бодлыг бусдад тулгаж буй эсэхийг болохыг мөн тэр үг тань жинхэнэ хайраас үүдэлтэй юу гэдгийг шалгаж үзэх хэрэгтэй.

2. Хэрэв би эш үзүүлэх чадвартай, мөн бүх нууцууд болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч

Энгийн үгээр тайлбарлавал “Эш үзүүлэг” гэдэг нь ирээдүйд болох ямар нэгэн зүйлийг зөгнөн хэлэхийг хэлдэг. Библид, үзвэл тусгай зорилготойгоор Ариун Сүнсний бялхам байдалд хөтлөгдөж Бурханы сэтгэлийг хүлээн

авч, дамжуулан ирээдүйд болох зүйлсийг зөгнөн хэлж байсныг харж болох юм. Энэ нь хүний хүслээр болдоггүй бөгөөд харин Ариун Сүнсээр бялхам байдалд хөтлөгдөн, Бурханаас хүлээн авч ярьдаг (2Петр 1:21).

Гэвч хайрын бүлэгт гардаг “эш үзүүлэх” гэдэг нь тусгай, сонгогдсон хүнд өгөгдсөн бэлгийг хэлж буй хэрэг биш юм. Эцэстээ Эзэн агаар мандал дээр буун ирж, аврал хүртсэн хүмүүс амрах 7жилийн хурим найранд орох юм. Аврал хүртэж чадаагүй хүмүүс нь 7жилийн гай зовлонг туулан, Их цагаан сэнтийн шүүлтийн дараа тамд хаягдах болно. Энэ үнэнийг мэдээд зөгнөн тунхаглахыг хэлж байгаа билээ.

Мөн “нууцууд” гэдэг нь өнө эртнээс далдлагдсан нууц, өөрөөр загалмайн утга учрыг хэлж байгаа юм. Загалмайн утга учир бол Бурхан хүн төрөлхтөнийг аврахын тулд өнө эртнээс, дэлхий ертөнцийг бүтээж эхлэхээс ч өмнө төлөвлөсөн зүйл юм. Бурхан хүн гэм нүгэл хийж үхлийн зам руу явна гэдгийг урьдаас мэдэн, өнө эртнээс аврагч Эзэн болох Есүсийг бэлдсэн юм. Энэ авралын төлөвлөгөө биелэгдэх хүртэл Бурхан далд нууцалсан байдаг. Авралын төлөвлөгөө илчлэгдвэл муу ёрын сүнс саад хийж биелэгдэх боломжгүй болох учраас тэр юм.

Муу ёрын сүнс сатан нь Есүсийг л алвал Адамын хийсэн гэм нүглээс болж олж авсан эрх мэдэл нь хэвээрээ хадгалагдан үлдэж чадна гэж бодож, хорон муу хүмүүсээр дамжуулан Есүсийг цовдлоход хүргэсэн. Гэтэл ямар ч гэм нүгэлгүй Есүсийг устгаснаар авралын зам нээгдсэн юм. Энэ мэт гайхамшигт нууцыг мэдэж байгаа ч хэрэв бидэнд сүнслэг хайр байхгүйн улмаас хүмүүст энэ тухай хэлж ярьж номлохгүй л юм бол энэ нь ямар ч ашиггүй юм.

Мэдлэг ч мөн адил юм. “Бүх мэдлэг” гэдэгт зөвхөн өөрийн сурч, мэдсэн онолын мэдлэг төдийгүй мөн библид агуулагдсан жинхэнэ үнэний мэдлэг ч бас багтдаг. Бид Бурханыг таньж мэдвэл Түүнийг хүлээн зөвшөөрч Түүнтэй уулзсанаар чин сэтгэлээсээ итгэх хэрэгтэй юм. Тэгэхгүй бол мэдлэг төдийхөн зүйл бөгөөд тэр мэдлэгээр бусдыг дүгнэж шүүх хэрэгсэл болох үе ч байдаг. Тиймээс сүнслэг хайргүй мэдлэг бол мөн л хэрэггүй зүйл юм.

Мөн хэрэв бидэнд “уулыг нүүлгэх агуу итгэл” байсан ч хайр байхгүй бол бид юу ч биш юм. Петр Есүсийг усан дээр явж байх үед хэсэгхэн хугацаанд л итгэлээрээ усан дээгүүр явсан. Тухайн үед Петр

Ариун Сүнсийг ч хүлээж авах юм уу, зүрх сэтгэлийн хөвч хөндөлтийг хийгээгүй, сүнслэг хайр ч байхгүй үе учир өөрийн аминд аюул учрах үед Есүсийг үгүйсгэж байсан билээ.

Энэ мэт Бурхантай уулзвал итгэл өсдөг боловч сүнслэг хайр нь гэм нүглээ хаяхын төлөө хичээнгүйлэн зүтгэх үйлс болон золиослох үед л бий болдог юм. Хайр, итгэл гэдэг нь хоорондоо хамааралгүй гэсэн үг биш ба итгэл байгаа учраас гэм нүгэл, хорон мууг хаяж, нь Бурханыг хайрлахыг хэлж байгаа юм.

3. Хэрэв би өөрийн бүх л өмч хөрөнгөө ядууст тараан өгч, өөрийн биеийг шатаахаар тушаасан ч

Хийсэн зүйлийнхээ төлөө магтуулж, гайхуулахын тулд ядууст тусладаг хүмүүс магтаал, хүндэтгэлд улам биеэ тоож, бардам болдог. Тэд өөрийгөө зөвт хэмээн андуурч, зүрх сэтгэлийн хөвч хөндөлтийг хийдэггүй тул эцэстээ өөрөө л хохирдог. Харин хайраас үүдэлтэй тусламж нь өөр хэн нэгэн бусад хүмүүс мэдэх, мэдэхгүй нь огтхон ч хамаагүй байдаг. Нууцаар харагч Бурхан үйлдсэний дагуу ивээл ерөөлийг шагнал болгон өгдөг гэдэг итгэдэг учраас тэр юм (Матай 6:3-4).

Золиос ч мөн адил юм “Биеэ шатаахаар тушаана” гэдэг нь өөрийгөө тэр чигээр нь зориулан, золиослох гэсэн утгатай. Мэдээж бидэнд хайр байсан цагт л золиос гарган өөрийгөө зориулж чадна. Гэтэл маш их хичээн зүтгэхчээд тавгүйдтэг үе бий. Өөрийн хүч, сэтгэл санаа, цаг, эд хөрөнгө бүхнээ зориулж байхад хэн ч ойлгож өгөхгүй бол гомддог. Олигтой хичээхгүй байгаа хүнийг хараад “Бурханд хайртай гэдэг мөртлөө яаж ингэж чаддаг байна?” гэж дүгнэн боддог. Ингэж бодсоноороо өөрийгөө хүнд байдалд оруулж, бусадтай эв нэгдэл хагалдаг. Тиймээс ийм золиос нь ямар ч ашиг тусыг өгөхгүй.

Тэгвэл итгэлтэй байлаа ч яаж хайр байхгүйгээр золиос гаргах вэ? Энэ нь чин сэтгэлээсээ “надад байгаа нь Бурханых, Бурханд байгаа нь минийх” гэсэн эзэгнэх, эзэмших сэтгэл байхгүй учраас тэр юм. Хэрэв бидний зүрх сэтгэлд сүнслэг хайр дүүрэн байвал хэн нэгэн харсан ч, хараагүй байсан ч Эзэний төлөө өөрийгөө бүрэн зориулж чадна.

Хайрт итгэгч нар минь, Лаа өөрийн биеэ урсган шатааж, харанхуйг гэрэлтүүлдэг шиг та бүхэн ч гэсэн харамгүйгээр бусдын тусын тулд зориулж чадах сүнслэг хайрыг төгс олж авахыг Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
 www.manmintv.org



Есүс төрсөнийг зарлан мэдүүлсэн Габриел Тэнгэр элч болон Тэнгэрийн элчүүдийн үйлс

◆ **Тоологдошгүй үй олон тэнгэр элч нар**
Сүнслэг ертөнцөд орших Бурханы бүтээсэн тэнгэр элч нарыг тоолохын ч аргагүй асар олон билээ. Тэнгэр элч нарын орших газар бол энэ газрын ямар ч улсын төрийн зохион байгуулалт болон дэг журмуудаас хамаагүй сайн зохион байгуулалттай байдаг ба тэд эмх цэгц, хэв журам нь маш нарийн, чадварлаг түвшинд бэлтгэгдсэн байдаг бөгөөд тэд тус бүр ахлах тэнгэр элчийн тушаалаар ажилладаг байна.

Тэргүүн тэнгэр элч бол тэнгэр элч нарын удирдагч бөгөөд энэ газрын сайдтай адил үүрэг гүйцэтгэдэг юм. Тэргүүн тэнгэр элч нь Бурханы гар, хөл, нүд, чих болох үүрэгтэйн хувьд бүхийл талбарыг ажиглан, Бурханы шууд тушаалын дагуу хөдөлж, мөн эргэж тайлагнадаг ба Тэргүүн тэнгэр элчийн доор шууд хамаарах үй олон тэнгэр элч нар ажиллаж байдаг.

Бидний сайн мэдэх жишээ бол Тэргүүн тэнгэр элч Габриел ирээдүйд болох илчлэлтийн тухай мөн агуу хүчтэй залбирлуудад Бурханы айлдсан хариулт гэх мэт чухал мэдээг дамжуулдаг үүргийг гүйцэтгэдэг (Лук 1:19, 26; Даниел 9:21-23). Тэргүүн тэнгэр элч Михайл бол тэнгэрийн орны цэргийн ерөнхий захирагч, Жанжин нь бөгөөд атгаг, харанхуйн сүнснүүдтэй тулалдаж, заримдаа тэр өөрөө харанхуйн хүчнүүдийг устган сүйрүүлдэг юм (Илчлэлт 12:7-8; Даниел 10: 13-14).

Үүнээс гадна өөр олон төрлийн тэнгэр элч нар байдаг ба аюул ослоос авардаг тэнгэр элч, (Даниел 6:22; Үйлс 12-р бүлэг); бидний залбирлуудыг Бурханы сэнтийд дамжуулагч тэнгэр элч, (Илчлэлт 8:3-4); хүчирхэг тэнгэр элч (Илчлэлт 10:1, 18:21); Бурханы шүүлт, шийтгэлийг биелүүлэгч тэнгэр элч, (2 Самуел 24:16); тэнгэрлэг дайчид (Дуулал 103:21, Лук 2:13); Бурханы хүүхдүүдэд үйлчлэгч тэнгэр элч (Еврей 1:14); болон Тэнгэрт хүмүүсийн хэлсэн бүх үг хийгээд үйлсийг тэмдэглэдэг тэнгэр элч (Матай 18:10) байдаг юм.

◆ **Есүс төрсөнийг зарлан мэдээлсэн Тэргүүн тэнгэр Элч Габриел**

Лук 1:26-38-д тэргүүн тэнгэр элч Габриел Бурханаас онгон Мариа руу илгээгдэж Есүсийг хэрхэн яаж төрөх тухай мэдүүлдэг тухай гардаг.

Галилын Назар гэдэг хотод амьдарч байсан Мариагийн өмнө тэргүүн тэнгэр элч Габриел гарч ирээд “Харагтун, чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ тэгээд чи Түүнийг Есүс гэж нэрлэх болно” гэж хэлэхэд нь Иосефтэй дөнгөж сүй тавиад удаагүй байсан Мариа онгон байсан учраас “Яаж ийм юм болох билээ?” гэж хэмээн асуудаг.

Тэгэхэд нь Габриел “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээд Нэгэний хүч чамайг бүрхэнэ; тиймээс ариун хүүхэд төрж, Бурханы Хүү гэж дуудагдах болно” гэж айлддаг. Тэр, Мариад Бурханы хүчээр, Ариун Сүнсний хүчээр хүүхэдтэй болох болно гэдгийг мэдүүлж өгч байгаа юм. Харин Мариа дуулгавартайгаар “Эзэний шивэгчнийг харагтун. Хэлсэн үгийн тань дагуу надад биелэгдэх болтугай” хэмээн хариулдаг. Үүн шиг тэргүүн тэнгэр элч Габриел Бурханы тушаалаар хүмүүст үзэгдэн, чухал мэдээг дамжуулдаг юм.

◆ **Итгэгчдэд үйлчилж, тэднийг хамгаалдаг тэнгэр элч нар**

Сүнсний ертөнцөд тусгай ажил үүрэг гүйцэтгэдэг тэнгэр элч нар байдаг. Энэ нь Бурханы үр хүүхдүүдэд үйлчилдэг тэнгэр элч нар ч бас байдаг юм (Еврей 1:14). Эдгээр тэнгэр элч нар Бурханы үр хүүхэд Бурханы сургааль дотор амьдрах үед л хамгаалах ёстой эздээ хамгаалж байдаг бөгөөд

Хайрын Бурхан Өөрийг нь дуурайсан үр хүүхдүүдтэйгээ хамт үзэсгэлэнтэй тэнгэрийн оронд жинхэнэ аз жаргалыг эдлэн, харилцан хайрыг өгч авахын тулд “Хүнийг дасгалжуулан боловсруулалт” төлөвлөн түүнд хэрэглэх бүхнийг бүтээсэн билээ. Тэр зүйлсийн нэг нь бол Бурханы ажилд туслах “тэнгэр элч” болон “херуб” гэсэн сүнслэг орших туслахуудыг бүтээжээ. Христмас баярын өдөр хүн төрөлхтөнийг боловсруулан дасгалжуулахад тусалдаг тэнгэр элч нарыг үүргийг судалж үзэнгээ, бидэн рүү хандсан Бүтээгч Бурханы хайрыг чин сэтгэлээсээ ойлгож ухаарцгаая.

тэднийг итгэлээр өсөх тусам, сүнслэг зүрх сэтгэлийг олж авах тусам илүү том, хүчирхэг тэнгэр элч нар тэднийг хамгаалан үйлчилж байдаг.

Эдгээр тэнгэр элч нар эзэн нь аз жаргалтайгаар магтан дуулах юм уу бүжиглэх үед хөгжилтэйгөөр дуурайж хийх юм уу, инээвэл хамт инээдэг. Мөн эзэн нь уйтгар гунигтай байвал тэнгэр элч ч бас уйтгар гунигтай байх бөгөөд юу ч хийхгүй дэмий л гиюүрэн суудаг. Хэрэв эзэн нь муу муухай үг яриа ярьж, хэн нэгнийг гутаан доромжилж, бусдыг өвтгөн шаналгах зүйл ярих юм бол тэнгэр элч нь тэдэнд туслаж чадахгүй бөгөөд Бурханы шударга ёсны дагуу эзэнээсээ холдож, улмаар эзэнээ хамгаалж чадахгүйд хүрдэг.

◆ **Итгэгчдийн залбирлыг анхилуун утлага болгон дамжуулагч тэнгэр элч нар**

Залбирах үедээ хүн тус бүр тэр залбирлыг анхилуун утлага болгон хүлээн авдаг тэнгэр элчүүд байдаг (Илчлэлт 8:3-4). Залбирч буй хүн нь хэр зэрэг Бурханы хүлээж авах хэмжээний залбирал хийж буйгаас шалтгаалан уг залбирлыг дамжуулах тэнгэр элч нарын зэрэг зиндаа өөр байдаг. Энэ залбирлын утлага нь Бурханы өргөөний хойморт байрлах дээд индэрт байрлах алтан бойпорт хуримтлагддаг. Тэр алтан бойпорыг ердийнхөөс арай өндөр зэрэглэлийн тэнгэр элч агаарт авч яваад өөр бас өөрөөсөө өндөр зэрэглэлийн тэнгэр элчид дамжуулж өгдөг. Тэгээд эцэстээ тэргүүн тэнгэр элчид дамжуулагдаж Бурханы сэнтийн өмнө алтан тахилын ширээн дээр асар том бойпортой бидний залбирлын анхилуун үнэрт утлагыг авч ирж байдаг.

◆ **Хүмүүсийн бүх бодол, зүрх сэтгэл, үг, үйлдэл бүрийг тэмдэглэдэг тэнгэр элчүүд**

Тэнгэрт буй тэнгэр элч нар нь энэ газар дээр амьдарч байгаа бүх хүн нэг бүрийг хариуцан авч, тухайн хүний үг, яриа, бодол санаа, зүрх сэтгэл, үйлдэл бүрийг тэмдэглэж авдаг ба өөрсдийн дээр байдаг тэнгэр элч нарт хүлээсэн үүргийн дагуу маш нарийн тайлагнадаг. Тэр тэнгэр элч нар нь мөн л өөрсдийн дээр байдаг тэргүүн тэнгэр элч нар мэдээлж энэ мэдээлэл нь Бурханы сэнтийд алтан бойпор дотор хадгалагдана. (Матай 18:10). Тэнгэр элч нарын үүрэгт ажлаар дамжуулан Бурхан хүн нэг бүрийг сайн таньж мэдэх чадвартайг эндээс олж мэдэж болох юм.

◆ **Тэнгэр элч хүний дүр төрхтэй адилхан харагддаг**

Тэнгэр элчийн дүр төрх нь далавчтай л болохоос яг хүнтэй адилхан харагддаг (Марк 16:5; Иохан 20:12; Үйлс 1:10-11). Хэдийгээр тэнгэр элч нар хүлээсэн үүрэг даалгаврынхаа дагуу гадна төрх, зан ааш нь эрэгтэй, эмэгтэй хүнтэй адилхан байдаг. Жишээлбэл, тэнгэрлэг дайчдын захирагч тэнгэр элч бол эрэгтэй хүний дүр төрхтэй байх юм. Бүжиглэдэг, магтан дуулдаг тэнгэр элч нь эмэгтэй хүний дүр төрхтэй байдаг. Гэхдээ бүжиглэдэг эрэгтэй тэнгэр элч байдаггүй гэсэн үг биш юм.

Өөрсдийн үүрэг даалгаврын дагуу тэнгэр элч нарын зан ааш нь өөр өөр байдаг. Жишээ нь, дуулж, бүжиглэдэг тэнгэр элч нар үргэлж гэрэл гийсэн инээмсэглэдэг, төрхтэй бол эсрэгээр, хамгаалах үүрэгтэй тэнгэр элч нар хатуу шийдэмгий харцтай, бөгөөд бараг инээдэггүй шахуу төрхтэй байдаг билээ. Энэ мэт тэнгэр элчүүд нь Бурханы үйлчлэгч болохынхоо хувьд эдгээрээс гадна маш олон үүргийг гүйцэтгэдэг билээ.





Пиере Блат болон түүний эхнэр Алине Блат

“Цаг хугацаа орон зайг даван гарсан залбирлын ачаар өвчнөөсөө эдгэрч, амьдрал минь шинэчлэгдсэн”.

Пиере Блат итгэгч
(Бельги Эну Манмин Сүм)

Эхнэр бид хоёр 40 жилийн турш итгэлийн амьдралаар амьдарч хирэндээ итгэмжтэй үйлчилдэг байлаа. Удаан хугацааны турш залбирч, библи судлан олон цагыг өнгөрөөдөг байв. Гэвч миний амьдрал Эну Манмин Сүм (Хариуцсан ахлагч Ну Хёон суг СМТ)-д хамрагдаж эхэлсэнээс хойш бүрэн өөрчлөгдсөн.

Саяхан би доктор И Жейруг тэргүүн пасторын “Загалмайн Сайн Мэдээ” номыг сэдэв сэдвээр нь уншиж, Есүс Христ ба авралын зорилгыг маш тодорхой сайн ойлгож авлаа. Үүнд (номд) агуулагдсан Бурхан ба Эзэний хайрыг ухаарч итгэл маань өссөн юм.

Би хоёр удаа зүрхний хагалгаанд орсон бөгөөд уушигний үйл ажиллагаа алдагдсан учраас 24 цагийн турш амьсгалын аппараттай байх шаардлагатай байлаа. Цусан дах сахарын хэмжээ мөн холестрин маш их байсан учраас өдөрт хоёр удаа инсулин тариагаар хийлгэдэг байв. 2012 оны 11-р сарын 16 нд би Манмин Төв Сүм рүү интернетээр залбирал авах хүсэлт явуулаад Баасан гаригын оройн цуглаанаар доктор И Жейруг тэргүүн пасторын цаг хугацаа, орон зайг давсан залбиралыг авсан юм. Гэтэл үнэхээр гайхамшигтай зүйл тохиолдов. Залбиралын дараа өдөр тутамд хэрэглэдэг байсан амьсгалынхаа гуурсыг хэрэглэхгүй байх хэмжээний хэвийн болсон байлаа.

Шинжилгээний хариу гемоглобин А1с 8.0-оос 6.1 хүртэл буурсан, холестриний хэмжээ ч бууран хэвийн болсон байлаа. Цус маш сайн цэвэршиж яг л залуу хүний шиг болсон байсан. Уушигний үйл ажиллагаа бас хэвийн болов. Сүнс, махан талын ерөөлийг өгсөн Эцэг, Хүү, Ариун Сүнс Гурвын нэг Бурхандаа бүх алдар, магтаал, хүндэтгэл, талархалыг өргөж байна.

“Надад эрх чөлөөг өгсөн Өмнөд Солонгост би Бурхантай уулзсан учир тэнгэрийн оронд байгаа мэт санагддаг”.

У Хян ги Сүмд үйлчлэгч (Эзэний хайр бүлэг)

2006 оны 6-р сард маш олон хэцүү бэрхшээл саадыг даван туулсаны эцэст Хойд Солонгосын хилийг давж, Хятад, Тайландаар дамжин би Өмнөд Солонгост ирсэн юм. Амьд мэнд эрх чөлөөний энэ газарт ирэх боломжийг өгсөн нь зөвхөн Бурханы ивээл байлаа. Ингэж Өмнөд Солонгост ирсэний дараа засгийн газрийн мөнгөн дэмжлэгээр ямар ч хэцүү зүйлгүй амьдрах болсон ба надад шинэ орчинд дасан зохицоход тийм ч хэцүү байгаагүй юм.

2008 оны 6-р сард Хойд Солонгосоос дүрвэн ирсэн нөхөртэйгөө би дахин гэрлэсэн нь миний амьдралын их эргэлт болсон явдал байв. Энэ нь би нөхрийнхөө найзын урилгаар Манмин Төв Сүмд бүртгүүлэх явдал байлаа. Би бүртгүүлэх үед шинэ ирэгсдийн бэлэг болох доктор И Жей руг тэргүүн пасторын “Үхлийн Өмнө Мөнхийн Амьдралыг Амтлах нь” гэдэг номыг авсан юм. Би энэ номыг гэртээ тэр дор нь шахуу уншиж дуусгасан бөгөөд үүнээс би маш их сэтгэл хөдлөл ба ивээлийг авсан юм.


Үүний дараа би тэргүүн пасторын “Загалмайн Сайн Мэдээ”, “Итгэлийн Хэмжүүр”, “Диваажин” ба “Там” гэсэн номнуудыг уншиж, бичиж тэмдэглэн, товчлол хөтлөж эхэлсэн. Би энэ бүгдээс урьд нь мэдэхгүй байсан Бурханы зүрх сэтгэл, хүсэл, хайрыг мэдэрсэн бөгөөд итгэлээр ч өсөн аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байлаа. Ялангуяа, манай Манмин Төв Сүмд хойд Солонгосын цагаачдаас бүрдсэн “Эзэний хайр” бүлэг байдаг тул итгэлийн амьдралаар амьдрахад үнэхээр их тус дэм болсон юм. Хойд Солонгосын цагаачид бидэн рүү хандсан доктор И Жей руг тэргүүн пасторын хайр халамж үнэхээр онцгой учраас тэр юм.

Нэлээн дээхнэ үеэс миний нүд аргаж загатнадаг байлаа. Нүднээс үргэлж нуух гоожиж, цус хураад, харааны шил зүүдэг ч сайн харж чаддаггүй байв. Эцэст нь, эмнэлэгт очин шинжилгээ хийлгэсэн бөгөөд үүний хариу нь хөгшрөлтийн улмаас нүдний болор

цайсан тул хагалгаанд орох шаардлагатай гэж эмч хэлсэн билээ. Гэвч би доктор И Жей руг тэргүүн пасторын удирдсан “Онцгой эдгэрэл ивээлийн цуглаан”-д оролцож итгэлээрээ эдгэрэхийг хүсэж байлаа. Тэгээд би үүний төлөө залбирч, өөрийгөө бэлдсэн.

2011 оны 6-р сарын 10-ны өдөр “Онцгой эдгэрэл ивээлийн цуглаан” дээр доктор И Жей руг тэргүүн пастор миний нүдэн дээр гар тавин залбирч өгөхөд маш халуун гэрэл цацарч байгааг мэдэрсэн юм. Гайхалтай нь бүрэлзээд юм харахад хэцүү байсан нүд маань залбирлын дараа тэр дороо л маш тод харж чаддаг болсон юм. Одоо миний хоёр нүдний хараа хоёулаа их сайн болсон бөгөөд хэдийгээр би 70 настай ч нүдний шилгүйгээр зүү, утас амархан сүвлэж, жижиг үсэгтэй бичгийг сайн уншиж чаддаг. Мөн тэр өдөр талархалтай нь өвдөгний үе мөчний өвчний мээ заслын үрэвсэл, цусны даралт ихдэх өвчнөөс хүртэл төгс эдгэрсэн юм.

Би ийм гайхалтай, сайн Бурханы ивээлийн хариуд би өөрийнхөө “Итгэмжит байдлын талаарх тэмдэглэл” бий болгон нэг нэгээр нь бичиж байгаа юм. Энэ нь Бурханы хаанчлалын төлөө итгэмжтэйгээр хийх ажлыг хайн хийдэг болсон юм. Өнгөрсөн жилийн 7-р сараас эхлэн долоо хоног болгон 1500 ширхэг Манмин сонинг тарааж байна. Би Өмнөд Солонгост ирээд амьд Бурхантай уулзаж, Түүний хайран дотор жинхэнэ эрх чөлөөг олж авсандаа маш их аз жаргалтай байна. Дулаахан хайраараа тэвэрч өгсөн Эзэн, амийн үг сургаалиар ерөөлийн зам руу замчилж өгсөн И Жей руг тэргүүн пасторгаа чин сэтгэлээсээ талархсанаа илэрхийлье.



“Мүан амтат ус хэрэглэсэний дараа хуйх загатнахаа больж, цустай идээ цэвэрхэн эдгэрсэн”.

Гиованна Пандо итгэгч (Перу Манмин Сүм)



2012 оны ихээр 5 настай охин Ана маань хуйхны үрэвсэн өвдөж эхэлсэн юм. Үүний улмаас цусархаг идээ гарахын зэрэгцээ загатнаж, хурц зовиуртай байсан учраас үс нь унаж байлаа. Эмч нар өвчний учир шалтгааныг хэлж мэдэхгүй байна гэдэг байсан бөгөөд үргэлжлүүлэн эмчилгээ хийлгэсээр байсан боловч бүр их загатнаж, өвчин нь улам бүр хүндэрч, даамжирсаар байлаа.

Яг энэ үед, Перу Манмин Сүмийн нэгэн итгэгч Муан амтат усыг хэрэглэхийг надад зөвлөсөн юм.

Тэр хэрэв би итгэлээрээ үүнийг хэрэглэвэл Бурхан миний охиныг эдгээж өгөх болно гэж хэлсэн. (Мүан Амтат ус бол Бурханы хүч шингэсэн бөгөөд доктор И Жей руг тэргүүн пасторын залбирлаар далайн шорвог ус амтат ус болон өөрчлөгдсөн ус юм.)

Тэгээд би чин сэтгэлээсээ залбирч Мүан амтат усыг охиныхоо хуйханд цацсан. Үүний дараа гайхамшигтай цустай идээ хатаж, хуйхан дээрх идээ нь арилсан юм. Ердөө л 6 өдрийн дараа хуйх нь цэв цэвэрхэн болж, үсгүй болсон газраар нь үс нь ургаж эхэлсэн шүү! Халелүяа!

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
12-р хороо, Хангайн 3-57 тоот
Улаанбаатар Ариун баярт мэдээ
чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин